



**Харилцаа холбооны зохицуулах хорооны  
2021 оны ээлжит бус 02 дугаар хуралдааны  
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны ээлжит бус 2 дугаар хуралдаан 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдөр холимог оролцоотой (биеэр болон цахим) хэлбэрээр болов.

УИХ-аас 2019 оны 5 дугаар сард Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг соёрхон баталсан бөгөөд энэхүү хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.16 дах заалт (*9.1.Зохицуулах хороо харилцаа холбооны талаар төрөөс баримтлах бодлогын хүрээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ; 9.1.16-Зохицуулах хорооны төсөв, ажлын албаны жилийн төлөвлөгөөг батлах*)-аар Хорооны хуралдаанаар байгууллагын жил бүрийн төсөв, үйл ажиллагааны төлөвлөгөөг 2019 оноос эхлэн баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байгаа билээ. Түүнчлэн Засгийн газрын 2016 оны 268 дугаар тогтоолоор баталсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм”, “Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 2020 оны 65 дугаар тогтоолын 4 дүгээр зүйлийн 4.3.2. заалт “*Хорооны төсөв, ажлын албаны жилийн төлөвлөгөөг батлах; (Энэ дэд заалтыг Засгийн газрын 2020 оны 65 дугаар тогтоолоор нэмсэн)*”-ыг үндэслэн хорооны хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж байгаа билээ.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны ээлжит бус 2 дугаар хуралдаанаар Хорооны даргын 2022 оны А/290 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг, бүтцийн ажлын албанаас нэгтгэн боловсруулсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл, орлого зардлын төлөвлөгөө, байгууллагын 2024-2025 оны төсвийн төсөөллийг батлах тухай” тухай танилцуулга, тогтоолын төсөл, хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөр, төсөв тооцоо, орлого зарлагын судалгаа, төлөвлөгөөний төсөл болон тогтоолын хавсралтууд болох “Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ)-ны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний төсөл, “ХХЗХ-ны 2023 оны орлогын төлөвлөгөө”-ний төсөл, “ХХЗХ-ны 2023 оны зардлын төлөвлөгөө”-ний төсөл, “ХХЗХ-ны 2023 оны хөрөнгө оруулалтын зардал”-ын төсөл, “ХХЗХ-ны 2023 оны хөтөлбөр, арга хэмжээний зардал”-ын төсөл, “ХХЗХ-ны 2023 оны үйл ажиллагааны зардал”-ын төсөл, “ХХЗХ-ны 2024-2025 оны төсвийн төсөөлөл”-ийн төслийн баримт бичгийн анхны хэлэлцүүлгийг тус тус хийж, энэхүү хуралдаанаас байгууллагын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн урьдчилсан тайлан болон төсвийн гүйцэтгэл, 2023 оны төлөвлөгөөтэй хийсэн харьцуулалт, хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын томоохон хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлтийн аргачлал, бүтцийн нэгж, газар хоорондын уялдаа холбоог сайжруулах, ХХЗХ-ны 2022 оны 42 тоот тогтоолоор баталсан 2022-2025 оны дунд хугацаанд стратеги, зорилтууд, хорооны санхүүгийн нөөц, чадварыг дээшлүүлэх талаар арга хэмжээг тусган боловсруулах, хорооны хуралдаанд дахин хэлэлцүүлэх, батлуулах арга хэмжээ авч ажиллахыг Ажлын хэсэг (Д.Сэрээдорж) болон холбогдох бүтцийн нэгжийн газар, хэлтсийн удирдлага нарт хугацаатай үүрэг даалгавар, удирдамж чиглэл өгөхөөр тогтов.

(Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо  
2022-12-20